

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.УЧРАЛ

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 21 дүгээр зүйлд “Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;” гэж заасан байдаг.

Манай улс Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд хуулийн зорилт нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлсон байдаг нь уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Хуулийн төсөл боловсруулах практик шаардлага

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр өөрчлөлт оруулан жагсаал жагсаал цуглаан зохион байгуулагч жагсаал, цуглаан байгуулахдаа тухайн үйл ажиллагааг зохион байгуулах нутаг дэвсгэрийг харьяалах засаг даргад мэдэгдэл хүргүүлэх, уг мэдэгдлийг хүлээн авсан засаг дарга ажлын гурав хоногт хянан үзэж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх, тодорхой үндэслэл заан бүртгэхээс татгалзах зохицуулалт шинээр нэмсэн бөгөөд энэ нь практикт “бэртгэл” нэртэй “зөвшөөрөл” болж хувирсан.

Улмаар бүртгүүлээгүй жагсаал, цуглаан зохион байгуулсан этгээдүүдэд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэдэг болсон. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх чөлөө нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ

хэрэгжүүлэх гол механизм бөгөөд тодорхой үндэслэлээр хязгаарлахаас бусдаар хүн энэхүү эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломжтой байдаг.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд зааснаар хүний тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагаар хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болдог. Гэтэл өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтаар иргэдийн эрхийг засаг даргад төвлөрүүлэх боломж бүрдүүлээд байна. Нөгөө талаас төрийн зүгээс олон нийтийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах зорилгоор дайн, зэвсэгт мөргөлдөөнийг сурталчилсан зэрэг жагсаал цуглааныг зохион байгуулуулахгүй байхад хяналт тавьж, хуулиар хориглох нь зүйн ёсных боловч үүгээр шалтаглан хүний жагсаал цуглаан хийх эрхийг засаг дарга үзэмжээрээ шийдвэрлэдэг болоод байна.

Хуулийн дээрх зохицуулалтаас шалтгаалж иргэдийн Үндсэн хуулиар болон олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх зөрчигдөхөд хүрч, хуулийг сахиулах чиг үүрэг бүхий цагдаагийн албан хаагчдын дунд маргаан, зөрчилдөөн гарсаар байна. Иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ийнхүү илэрхийлэх арга замаа хуулиар хориглоогүй алга хэлбэрээр хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтнаас аливаа төрлийн зөвшөөрөл авдаг тогтолцоо байх учиргүй. Харин жагсаал, цуглаан хаана ямар хэлбэрээр болох, оролцогчдын болон олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор бүртгэх зохицуулалт байх нь зүйтэй юм.

Иймд хуулийн дээрх зохицуулалтад өөрчлөлт оруулан иргэдийн хуулиар баталгаажуулсан эрхийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь шаардлага байсаар байна

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулна. Үүнд:

- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлээс мэдэгдэл хүлээн авсан Засаг дарга хянан үзээд ажлын гурав хоногт багтаан бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэх, бүртгүүлсний дараа нийтэд зарлан мэдэгдэх талаарх зохицуулалтыг болон жагсаал цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг хянах зохицуулалт бүхий 10 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгох;
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан мөн хуулийн 14 дүгээр зүйлийн холбогдох хэсгээс хасах.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

- Хүн Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан тайван замаар, чөлөө жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө баталгаатай хэрэгжүүлэх үндэс бүрдэнэ
- Иргэд жагсаал, цуглаан зохион байгуулахдаа зөвхөн тухайн жагсаал цуглааныг зохион байгуулах нутаг дэвсгэрийн харьяалах Засаг даргад

мэдэгдэл хүргүүлэн бөгөөд мэдэгдлийг хүлээн авч бүртгүүлснээр зохион байгуулах боломж нь бүрдэнэ.

- Засаг дарга өөрийн үзэмжээр жагсаал цуглааныг зохион байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэдэг байдлыг хална.
- Жагсаал, цуглааны үеэр иргэд хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан, албан хаагч нарын дунд үүсдэг зөрчил арилах боломж бүрдэнэ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.

-----oO-----